

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2005 ОНЫ 5 ДУГААР САРЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

/2005.05.01-2005.05.31/

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСАГ

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны хооронд байгуулсан “Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх төсөл”-ийн зээлийн гэрээг УИХ-аар соёрхон батлуулав.

Монгол Улсын 2004 оны нэгдсэн төсөв болон Засгийн газрын жилийн эцсийн санхүүгийн тайланг УИХ-д өргөн мэдүүлэв.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2005 оны 4 дүгээр сарын гүйцэтгэлийг нэгтгэн боловсруулж мэдээлэв.

Эхний 4 сарын гүйцэтгэлээр улсын нэгдсэн төсвийн нийт орлого 206.0 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 11.1 тэрбум төгрөгөөр буюу 5.7 хувиар давж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 12.7 тэрбум төгрөгөөр буюу 6.8 хувиар өссөн байна.

Улсын нэгдсэн төсвийн зарлага 215.6 тэрбум төгрөг болж, төлөвлөгдсөн нийт зарлагын 81.6 хувийг санхүүжүүлсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхээс зарлага санхүүжилт 19.1 тэрбум төгрөгөөр буюу 9.7 хувиар өссөн байна.

Орон нутгийн төсвийн дүнгээр төсвийн орлогын төлөвлөгөө 3.5 хувиар тасарч, зарлагын 90.3 хувийг санхүүжүүлсэн байна.

Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн олгосон байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн урсгал тэнцэл (өссөн дүнгээр) **23.0** тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл **9.6** тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

Улсын төсөвт байгууллагуудын 2005 оны 4 дүгээр сарын төсвийн зарлагын гүйцэтгэлийн мэдээг төсвийн ерөнхийлөн захирагч нараар нэгтгэн гаргахад улсын хэмжээнд 2005 оны 5 дугаар сарын 1-ний байдлаар нийт авлага **5.36** тэрбум, нийт өглөг **5.4** тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Улсын төсвөөс 1110 төсөвт байгууллагад **31.9** тэрбум төгрөгийн зарлага санхүүжилт хийснээс халамжийн тэтгэвэрт 1.9 тэрбум, тэтгэврийн нөхөн олговорт 103.5 сая, тэтгэврийн даатгалын санд 3.9 тэрбум, олон хүүхэдтэйн тэтгэмжид 739.5 сая, төрөөс хариуцах эрүүл мэндийн даатгалын хураамжид 404.5 сая, эрчим хүчний алдагдлын зөрүүд 409,0 сая төгрөгийг тус тус олгосон байна.

Засгийн газрын нөөц хөрөнгөөс 840.6 сая, хуваарилагдаагүй зардлаас 72.7 сая төгрөгийг зарцуулсан байна. Орон нутагт 5 сард НӨАТ-ын буцаан олголтоор 933.0 сая, санхүүгийн дэмжлэгээр 571.0 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

Засгийн газар эхний 5 сард (өссөн дүнгээр) гадаад зээлийн үндсэн төлбөрт 7.7 тэрбум, хүүгийн төлбөрт 7.3 тэрбум, нийт **15.0** тэрбум төгрөг төлсөн байна. Мөн Засгийн газрын бондын үндсэн төлбөрт 4.7 тэрбум, хүүгийн төлбөрт 239.2 сая, нийт **4.94** тэрбум төгрөг төлсөн байна. Засгийн газрын өрийн бичгийн (өссөн дүнгээр) үндсэн төлбөрт 14.0 тэрбум, хүүгийн төлбөрт 186.6 сая, нийт **14.2** тэрбум төгрөг төлсөн байна.

Засгийн газар 29.9 тэрбум төгрөгийн зээлийг шинээр нэмж ашигласан дүнтэй гарлаа. Арилжааны банкуудаас дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу эхний 5 сарын байдлаар (өссөн дүнгээр) зээлийн үндсэн төлбөрт 4.2 тэрбум, хүүгийн төлбөрт 3.5 тэрбум, бүгд **7.7** тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх арга

хэмжээ авсан байна. Төрийн сангийн төгрөгийн болон гадаад валютын чөлөөт эх үүсвэрээс шөнийн (овернайт) зээл олгож, түүнчлэн Монголбанк болон арилжааны банкуудад богино хугацаат мөнгөн хадгаламжийг байршуулснаар нийтдээ төрийн санд **139.4** сая төгрөгийн хүүгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Захиалагч, гүйцэтгэгч нарын хооронд байгуулсан хөрөнгө оруулалтын 38 гэрээг хянан баталгаажуулж, улсын төсвийн хөрөнгө оруулалтын 11 төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, тайлант 5 дугаар сард 2817.1 сая төгрөгийн санхүүжилтийн 42 эрх нээснээс төрийн сангаас 1689.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

ҮЙЛДВЭР, ХУДАЛДАА

2005 онд улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын тендерийг зарлан төслүүдийг хүлээн авч, үнэлгээ өгч байна.

Нефьт бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг сайжруулах үүднээс Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын Оросын хэсгийн дарга Гордеевт ҮХ-ны сайд С.Батболд албан захидал хүргүүлэв.

Дэлхийн худалдааны байгууллагатай хамтран Үйлчилгээний худалдааны асуудлаар 2 өдрийн үндэсний семинар зохион байгуулав.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН

Ерөнхий боловсролын талаар:

Ерөнхий боловсролын сургууль 11 жилийн сургалтын тогтолцоонд шилжиж байгаатай холбогдуулан 2005-2006 оны хичээлийн жилийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор хичээлийн жилийн бүтэц болон бага, суурь, бүрэн дунд боловсролын шилжилтийн сургалтын төлөвлөгөөг батлан гаргав.

2005-2006 оны хичээлийн жилээс эхлэн ерөнхий боловсролын сургуулийн сурагчийн дүрэмт хувцсыг эцэг эхийн 50-иас доошгүй хувийн санал авсан загварыг сонгохыг нийт сургуулиудын захирлуудад даалгалаа.

Ерөнхий боловсролын 11 жилийн сургалтын сурах бичгүүдэд дүгнэлт гаргах шинжээчдийн дүгнэлтийг үндэслэн бага, дунд боловсролын болон сурах бичгийн стандартын шаардлагыг хангасан 21 сурах бичгийг 2005 онд хэвлэн сургалтад ашиглах зөвшөөрлийг олгов.

Мэргэжлийн боловсролын талаар:

МУ-ын Ерөнхий сайдын баталсан “Монголын оюутны холбооноос тавьсан хүсэлтийн дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх зорилгоор “Их, дээд сургууль, коллежид хандив авч элсүүлэхийг хориглох тухай” БСШУ-ны Сайдын тушаал гарч их, дээд сургууль, коллежуудад хүргэгдэв.

2005-2006 оны хичээлийн жилд төрийн өмчийн 10 сургуульд 16 мэргэжлээр, төрийн бус өмчийн 26 сургуульд 31 мэргэжлээр бакалаврын, 4 сургуульд магистрын, 6 мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд 8 мэргэжлээр тус тус сургалт эрхлэх зөвшөөрөл олголоо.

БНХАУ-ын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайдын орлогч, хатагтай У И-гийн манайд хийсэн айлчлалын үеэр “БНХАУ-д Монгол оюутан суралцуулах болон МУ-д

хятад хэлний багш ажиллуулах тухай БСШУЯ, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ардын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг байгуулав.

Соёл, урлагийн талаар:

Засгийн газар Соён гэгээрүүлэгч Г.Занабазарын мэндэлсний 370 жилийн ойг 7 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд Хархоринд тэмдэглэхээр шийдвэрлэв.

ХБНГУ-ын Бонн хотод 6 дугаар сарын 15-нд нээгдэх "Чингис хаан ба түүний өв залгамжлагчид" үзэсгэлэнд оролцох 331 ш үзмэрийг сонгон авч тээвэрлэх ажлыг зохион байгуулан гаалиар гаргах лиценз олгов.

"Чингис хааны иггээсэн Монгол төрийн бичиг хэрэглэсний 800 жилийн ойг тэмдэглэх тухай" МУ-ын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, монгол үндэсний хэл бичиг, түүнтэй холбогдолтой ёс заншил, уламжлал өвийг судлан сурталчлах зорилгоор "Үндэсний бичиг үсгийн баяр"-ыг зохион байгууллаа.

ЭРҮҮЛ МЭНД

МУ-ын эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 12.1 дүгээр заалтыг үндэслэн эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээний хувьсах зардлыг санхүүжүүлэх хэмжээ, амбулаторийн тусламж үйлчилгээний нэг даатгуулагчид ногдох зардлын хэмжээг баталж, магадлан итгэмжлэгдсэн, тусгай зөвшөөрөл бүхий улсын эмнэлгийн хэвтэн эмчлүүлэх болон амбулаторийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг 2005 оноос эхлэн шинэ тарифаар олгох болов.

УАЗ-31512 маркийн 27, УАЗ-3962 маркийн 14 автомашиныг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилан олгов.

Үндэсний зайлшгүй эмийн хангамж Улаанбаатар хотод 75.0, орон нутагт 70.0-82.0 хувьтай байна. Энэ сард импортын гэрээгээр ОХУ-ын "БурятФармация" эм ханган нийлүүлэх байгууллагаас 59 нэрийн 91.1 мянган ам.долларын эм бараа нийлүүлэв.

Үндэсний зайлшгүй эмийн хангамжид хязгаарлагдмал байсан болон манай эмийн бүртгэлд бүртгэгдээгүй 11 нэрийн зайлшгүй шаардлагатай эмийг Нидерландаас импортын гэрээ хийж санхүүжүүлээд байна.

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨР

Нийгмийн хамгааллын бодлого, зохицуулалтын талаар:

Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэврийг 7 дугаар сарын 1-нээс эхлэн 7.5 хувиар нэмэгдүүлж, 42.0 мянган тэтгэвэр авагчдад нийт 272.0 сая төгрөгийг 2005 онд нэмж зарцуулахаар боллоо.

Мөн 1945 оны чөлөөлөх дайн, баруун хилийн зэвсэгт тулгаралтад оролцсон нийт 2.8 мянган ахмад дайчдад тус бүр 200.0 мянган төгрөгийн нэг удаагийн буцалтгүй мөнгөн тэтгэмж олгохоор шийдвэрлэв.

Хүн амын хөгжлийн бодлого, зохицуулалтын талаар:

Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан Монголын эмэгтэйчүүдийн холбоо, Гэр бүлийн радио FM-104.5-тай хамтран "Гэр бүл ба бизнес" үзэсгэлэн худалдааг Скай худалдааны төвд зохион байгуулав. "Бүх хайрыг гэр бүл рүү" уриан дор явагдсан уг арга хэмжээнд эсгий урлал, нэхмэл, мод, төмөр эдлэл зэрэг олон төрлөөр 88 гэр бүл оролцов.

Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх зорилгоор Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбоотой 2005 онд хамтран ажиллаж, үйл ажиллагааг нь санхүүжүүлэх гэрээ байгуулав.

Хөдөлмөрийн зах зээлийн бодлого, зохицуулалтын талаар:

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, МУ-ын эдийн засаг, нийгмийг 2005 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд дэвшүүлсэн зорилтын хүрээнд "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай", "Зарим албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай", "Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын тогтоол гаргав.

Нийгмийн даатгалын, халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн талаар:

2005 оны 4 дүгээр сард нийгмийн даатгалын тэтгэвэрт олгох 40.1 тэрбум төгрөгийг бүрэн олгосон байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогод 34.6 тэрбум төгрөг оруулахаас 38.0 тэрбум төгрөгийг оруулж, төлөвлөгөөг 110 хувиар биелүүлжээ.

Нийгмийн даатгалын тэтгэврийн санхүүжилтэд 38.8 тэрбум, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтэд 6.6 тэрбум, тэтгэмжийн даатгалын санхүүжилтэд 1.5 тэрбум, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын санхүүжилтэд 1.4 тэрбум, ажилгүйдлийн даатгалын санхүүжилтэд 442.1 сая төгрөг, нийгмийн даатгалын санхүүжилтэд 48.8 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Мөн сард өссөн дүнгээр нийгмийн халамжийн тэтгэврийг 43184 хүнд олгож 2.4 тэрбум төгрөг, нийгмийн халамжийн тэтгэмжийг 409073 хүнд олгож 7.3 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нийгмийн халамжийн болон асрамжийн үйлчилгээнд 11436 хүн хамрагдаж, 88.4 сая, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн нийгмийн халамжийн үйлчилгээнд 6221 хүн хамрагдаж 246.5 сая, ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, үйлчилгээнд 32220 хүн хамрагдаж 566.6 сая төгрөгийг тус тус зарцуулжээ. Нийгмийн халамжийн үйлчилгээнд нийт 503786 хүн хамрагдаж 10.7 тэрбум төгрөг зарцуулсан байна.

4 дүгээр сард 2318 хүний 37.9 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 7148 хүний 108.3 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэмжийг Архангай, Говь-Алтай, Дорноговь, Дорнод, Өвөрхангай, Сэлэнгэ, Хөвсгөл, Хэнтий, Дархан-Уул аймгууд болон Сонгинохайрхан, Баянгол дүүргүүд хугацаанд нь бүрэн олгож чадаагүй байна.

БАЙГАЛЬ ОРЧИН

Засгийн газраас баталсан "Ногоон хэрэм" хөтөлбөрийн хүрээнд 13 аймгийн нутагт 315 га ойн зурвас газарт суулгац тарьж, худаг гаргах, хамгаалалтын хашаа барих ажлыг хийгээд байна.

Засгийн газрын 2005 оны 46 дугаар тогтоолын дагуу Усны хэрэг эрхлэх газар байгуулан үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг батлан ажиллаж байна.

“Идлэг шонхор хамгаалах зохистой ашиглах тухай” Засгийн газрын 2002 оны 163 дугаар тогтоолын дагуу Саудын Араб, Кувейт зэрэг орнуудын шейхүүдтэй идлэг шонхор барих гэрээ хийлээ. Уг гэрээний дагуу шонхорын төлбөр болох 360 000 ам.долларыг Сангийн яамны дансанд төвлөрүүлээ.

Хангайн нурууны байгалийн цогцолбор газарт хяналт шалгалт хийж, тус хамгаалалтын захиргааг Хархорин суманд шилжүүлэн байршуулав.

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг хянах 4 харуулаас нийт 200 сорьц авч, хүхэрлэг хий болон азотын давхар исэл гэсэн 2 үзүүлэлтийг шинжлэн тодорхойлов. Шинжилгээний дүнгээс харахад хөтөлбөрийн биелэлт УБ-1 харуул дээр 100%, УБ-2 харуул дээр 90.7%, УБ-3 харуул дээр 85.3%, УБ-4 харуулд 100%-тай байлаа. Азотын давхар ислийн дундаж агууламж 0.028 мг/м^3 , хамгийн их нь 0.072 мг/м^3 -д хүрч, нийт 100 ажиглалтаас 28 нь агаарын чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас тус тус давсан байна.

Үйлдвэрийн хаягдал усны сорьцыг Улаанбаатар хотын дүүрэг дэх таван цэвэрлэх байгууламжийн орох, гарах цэгээс нийт 10 сорьц авч бохирдлын болон химийн задлан шинжилгээ хийв. Шинжилгээний дүнд цэвэрлэх байгууламжуудаас гарч байгаа ус 12-85%-ийн цэвэршилттэй байна.

Энэ сард зохиосон хоногийн цаг агаарын урьдчилсан мэдээний дундаж таарц 90.1%, Улаанбаатар хотын мэдээний таарц 94.8% байна.

2005 оны 5 дугаар сард олон улсын рейсийн шугамд ниссэн 123, орон нутгийн шугамд ниссэн 192 нислэгийг цаг агаарын мэдээгээр хангаж үйлчилсэн. Буянт-Ухаа олон улсын буудал орчмын урьдчилсан мэдээ 218 удаа зохиож, мэдээний таарц 81.1% байна. Нислэгийн бүх төрлийн урьдчилсан мэдээний таарц 98.2 % байна.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТ

Орон сууцанд ашиглагдаж байгаа нийт цахилгаан шатны судалгааг гарган дүгнэлт хийв.

МУ-ын макро эдийн засгийн судалгааг Монголбанктай хамтран эцсийн хувилбараар гаргав.

ЗАМ ТЭЭВЭР, АЯЛАЛ ЖУУЧЛАЛ

Монгол Улс ТИР Карнейн хүрээнд барааг Олон улсын хэмжээнд тээвэрлэх тухай конвенцид нэгдэн орж, авто тээврийн хэрэгслээр гаалийн хөнгөвчилсөн горим бүхий олон улсын тээвэрлэлтийг гүйцэтгэх болж байгаатай холбогдуулан ТИР горимоор гүйцэтгэх тээвэрлэлтийн найдвартай ажиллагааг хангах “Аюулгүйн хуримтлал”-д зориулан хөрөнгө гаргах тухай Засгийн газрын тогтоол гарган шийдвэрлэв.

Тулгар төр байгуулагдсаны 800 жилийн ойг тэмдэглэх ажлын хүрээнд Японы хувийн хэвшлийн байгууллагуудын санхүүжилтээр зохион байгуулах “Мянган морьтон” ёслолын арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх тухай “Харилцан ойлголцлын санамж бичиг”-т гарын үсэг зурлаа.

МУ-ын Ерөнхийлөгчийн БНУУ-д хийсэн айлчлалын үеэр ЗТАЖЯ болон БНУУ-ын Бүс нутгийн хөгжил, төвлөрлийн асуудал эрхэлсэн яамдууд “Аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр”-т гарын үсэг зурав.

БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар Замын-Үүд, Эрээн хот хооронд баригдах 5.67 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын гүйцэтгэгчтэй гэрээ байгуулав.

МУ-ын хөлөг онгоцны бүртгэлийн компанийн Удирдах зөвлөлийн хурлыг Сингапурт зохион байгуулж дараах асуудлыг шийдвэрлэв. Үүнд:

- Хамтарсан компанийн хэлэлцээрийн дагуу энэ санхүүгийн жилээс эхлэн Монголын талын хувьцааг дахин 10.0 мянган хувьцаагаар нэмэгдүүлснээр нийт хөрөнгийн 50.0 хувьтай тэнцэх хувьцааг МУ-ын Засгийн газар эзэмших болов.
- Удирдах зөвлөлийн гишүүдийг энэ санхүүгийн жилээс эхлэн тэнцүү тоотой буюу 3х3 байхаар тогтож протоколд тусгуулав.
- Хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааны ашгаас манай Засгийн газарт хуваарилагдах улирлын төлбөр болох 88.300 ам. долларыг улсын төсөвт шилжүүлэв.

Жуулчдад үнэн зөв мэдээлэл өгөх зорилгоор жуулчны мэдээллийн төвийн салбарыг “Буянт-Ухаа” олон улсын нисэх онгоцны буудал, төмөр замын “Улаанбаатар” өртөөнд нээлээ.

Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын Орлогч ерөнхий нарийн бичгийн дарга Девид Де Виллерс МУ-д айлчлав.

ТҮЛШ, ЭРЧИМ ХҮЧ

Богдын голын УЦС-ын сувгийн шинэчлэлийн гэрээг гүйцэтгэгч талтай байгуулж гарын үсэг зурав. Тайширын УЦС-ыг барих төслийн хүрээнд шаардагдах шатахууныг гааль, НӨАТ-аас чөлөөлөх шийдвэр гаргав.

Улсын төсвөөс үйл ажиллагааны алдагдлын санхүүжилт авдаг үйлдвэрүүдэд нийт 1159.0 сая.төгрөг олгосон байна.

Түлш, эрчим хүчний яам болон БНСУ-ын Худалдаа, аж үйлдвэр, эрчим хүчний яамны хооронд Монгол Улсын говийн бүсэд нар, салхины цахилгаан станц байгуулах зорилгоор хамтарсан судалгаа хийх төслийг амжилттай хэрэгжүүлж дууссаныг тохиолдуулан Хоёр тал Харилцан Ойлголцлын Гэрээнд гарын үсэг зурав.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ

Газар тариалан эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд үрийн буудай олгох ажлыг зохион байгуулж, 30 гаруй аж ахуйн нэгжид 1337 тн үрийн буудай олгов.

Энэ хавар нийтдээ 171.7 мянган га-д үр тариа, 16.2 мянган га-д төмс, хүнсний ногоо, 3.5 мянган га-д малын тэжээлийн ургамал тариалахаар төлөвлөж, одоогийн байдлаар 72.0 мянган га-д үр тариа, 5.8 мянган га-д төмс, хүнсний ногоо тариалаад байна.

“Ногоон хувьсгал” хөтөлбөрийн хүрээнд аймгуудийн Хүнс, хөдөө аж ахуйн газар иргэдэд 207 тонн төмсний үр, 1300 кг хүнсний ногооны үр, 1500 ширхэг үхрийн нүд, чацарганы суулгац, мөн 10 гаруй аж ахуйн нэгжид бага оврын техник, тоног төхөөрөмжүүдийг хуваарилан олгох ажлыг зохион байгуулав.

Солонгос Улсын КОИКА байгууллагын төлөөлөгчидтэй “Шинэ худаг барьж байгуулах” төсөл хэрэгжүүлэх Санамж бичигт гарын үсэг зурав.

Малын гоц халдварт шүлхий өвчнөөс сэргийлэн аймаг, нийслэлийн 53 сум, 8 дүүргийн 2.6 сая өвчлөмтгий мал, амьтныг вакцинжуулав.

БНХАУ-ын Чанарын хяналт шалгалт, хорио цээрийн Ерөнхий газар болон хөдөө аж ахуйн машин техник үйлдвэрлэлийн “КАМКЕ” байгууллагатай “Монгол Улсаас адууны мах экспортлоход хорио цээр, ариун цэврийн шаардлагын талаар байгуулах Протокол”, “Монгол Улсаас ноос, хонь ямааны арьс, үхэр, адууны шир экспортлоход хорио цээр, ариун цэврийн шаардлагын талаар байгуулах Протокол”-д тус тус гарын үсэг зурав.

“Монгол Улсын ХХААЯ болон Францын хил хязгааргүй малын эмч нар ТББ-ын хооронд хамтран ажиллах тухай Санамж бичиг”-т гарын үсэг зурав.

“Монгол улсын ХХААЯ болон Дэлхийн Зөн Монгол ОУБ хооронд худаг, уст цэгийн хангамжийг сайжруулах тухай Харилцан ойлголцлын Санамж бичиг”-т гарын үсэг зурав.

БНАСАУ-ын ХАА-н дэд сайд Мүн Ын Жүн тэргүүтэй төлөөлөгчдийн Монгол улсад хийсэн айлчлалыг зохион байгуулж, “Монгол Улсын ХХААЯ болон БНАСАУ-ын Хөдөө аж ахуйн яам хооронд хамтран ажиллах тухай Санамж бичиг”-т гарын үсэг зурах ажиллагааг зохион байгуулав.

БАТЛАН ХАМГААЛАХ

Бодлого төлөвлөлт, гадаад хамтын ажиллагааны чиглэлээр

Бүх цэргийн Хар сүлдийг ХҮИ дугаар жарны модон тахиа жилийн зуны тэргүүн сарын шинийн 7-ны өдөр Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг дахь Өгөөмөр ууланд цэнгүүллээ.

2005 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татах, 2004 оны 1 дүгээр ээлжээр татагдсан дайчдыг халах ажлыг зохион байгуулав. Ерөнхий зориулалтын цэрэгт 1375 хугацаат цэргийн албан хаагч татаж, 125 иргэнийг сайн дурын үндсэн дээр гэрээт цэргийн албанд элсүүлэн авч анги, салбаруудад хуваарилав.

“Иракийн эрх чөлөө” олон улсын цэргийн ажиллагаанд оролцож буй цэргийн баг, “Афганистаны үндэсний армийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд үүрэг гүйцэтгэж байгаа Сургалтын хөдөлгөөнт багийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

ГАДААД БОДЛОГО

МУ-ын Ерөнхийлөгч Н.Багабанди БНУУ-ын Ерөнхийлөгч Мадл Ференцийн урилгаар БНУУ-д төрийн айлчлал хийв. Айлчлалын үеэр Аялал жуулчлал, Эрүүл мэндийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрүүд, Хөгжлийн хамтын ажиллагааны тухай яам хоорондын Санамж бичиг, 2005-2007 онд Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах яам хоорондын төлөвлөгөө, МУ-ын Онцгой байдал эрхэлсэн сайд, БНУУ-ын Дотоод хэргийн сайд нарын Гамшгаас хамгаалах салбарт хамтран ажиллах тухай хамтарсан мэдэгдэл зэрэг баримт бичигт гарын үсэг зурав.

Мөн Ерөнхийлөгч Н.Багабанди ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путины урилгаар Москва хотноо болсон Аугаа Эх орны дайны ялалтын 60 жилийн ойн арга хэмжээ, Индонезийн Жакарта хотноо болсон Ази, Африкийн дээд хэмжээний уулзалт, Бандунгийн бага хурлын 50 жилийн ойн ёслолын арга хэмжээнд оролцов.

МУ-ын Ерөнхий сайд Ц.Элбэгдорж Сингапур Улсад айлчилж Азийн Эдийн засгийн чуулга уулзалтад оролцов. Мөн Тайландын Вант Улсад айлчилж Ерөнхий сайд Т.Чинаваттай хэлэлцээ хийж мэдээллийн технологийн салбарт хамтран ажиллах, аялал жуулчлалыг хөгжүүлэх, аж үйлдвэрийн парк байгуулах зэрэг асуудлаар санал солилцсоноос гадна хоёр улсын Гадаад хэргийн яамд хоорондын хамтын ажиллагааны Протокол байгуулав.

Монгол-Туркийн Засгийн газар хоорондын эдийн засаг, худалдааны Хамтарсан хорооны 4 дүгээр хуралдаан Улаанбаатар хотноо болов.

Гадаад хэргийн сайд Ц.Мөнх-Оргил Улаанбаатар хотноо болсон “Хүн амын шилжилт хөдөлгөөний асуудлаарх Үндэсний дээд хэмжээний уулзалт” арга хэмжээнд оролцож “Гадаадад шилжих хөдөлгөөний өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт илтгэл тавьж хэлэлцүүлэв.

Монгол Улс Авилгалын эсрэг НҮБ-ын Конвенцид нэгдэн оров.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРЭГ

“Засгийн газрын тухай”, “Төрийн албаны тухай”, “Жагсаал цуглаан хийх журмын тухай” хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, “Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай” хуулийн төслүүдийг УИХ-д өргөн мэдүүлсний зэрэгцээ “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай” хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлж байна.

“Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай”, “Алс Дорнодыг чөлөөлөх дайны ялалтын 60 жилийн ойг тэмдэглэх тухай” хуулийн төслүүд, “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр”, Монгол Улс Азийн хөгжлийн банк хооронд “Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх зээлийн гэрээ”, “Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенци”, “Монгол Улсын 2006 оны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл”-ийг УИХ-д өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгов.

Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Ц.Сүхбаатар тэргүүтэй төлөөлөгчдийн ОХУ-д хийсэн айлчлалын үеэр Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам, Оросын Холбооны Улсын Мансууруулах бодисын эргэлтэд хяналт тавих холбооны алба хооронд Мансууруулах эм болон сэтгэцэд нөлөөт бодис, түүний түүхий эдийн эргэлттэй тэмцэх талаар хамтран ажиллах тухай Хэлэлцээрт гарын үсэг зурав.

Монгол Улсын Ерөнхий сайд, Шадар сайд, ЗГХЭГ-ын даргын харьяа агентлагуудаас хийж гүйцэтгэсэн ажлын талаар

ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРОО

Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн эд хөрөнгийг “Монголросцветмет” нэгдлийн менежментийн багаас хүлээн авав.

“Тамга тэмдгийн үйлдвэр” ТӨҮГ, “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-уудын 2004 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд шалгалт хийв.

“ДЦС-3” ТӨХК-ийн тоног төхөөрөмж, сэлбэгийн 5 багц тендерийн шалгаруулалтыг зохион байгуулав.

МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБОО, ТЕХНОЛОГИЙН ГАЗАР

Монгол Улсын хүн ам, айл, өрх, албан байгууллагуудын компьютерийн хэрэглээ, хангамжийн өнөөгийн байдал, цаашдын эрэлт хэрэгцээ, хандлагын талаарх “Цахим хувьсгал” судалгаа хийж дуусгалаа.

Олон улсад холбогдох өргөн зурвас бүхий интернэтийн нэгдсэн гарцтай болох, интернэтийн хэрэглээг нэмэгдүүлэх талаар “Улаанбаатар төмөр зам” болон “Орбитнэт” ХХК-тай хамтран ажиллах, Засгийн газрын мэдээлэл, холбооны сүлжээг шинэчлэх “Ай Пи утас” төслийг БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжүүлэхээр тус улсын “Зи-Ти-И” компанитай хамтран ажиллах санамж бичигт тус тус гарын үсэг зурав.

ШУДАРГА БУС ӨРСӨЛДӨӨНИЙГ ХЯНАН ЗОХИЦУУЛАХ ГАЗАР

Зах зээлд дангаар ноёрхож байгаа болон давамгайл байдалтай аж ахуйн нэгжүүдийг тогтоох зорилгоор улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 25.0 мянга гаруй аж ахуйн нэгжүүдийн 2003-2004 оны борлуулалтын орлого, гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 2003-2004 онуудад импортоор авсан 15.4 мянган нэр төрлийн барааны тоо хэмжээ, үнийн судалгааны талаар мэдээллийн сан бүрдүүллээ.

Агентлагийн үйл ажиллагааны чиг үүргийг сурталчлах, шударга өрсөлдөөний талаарх ойлголтыг олон нийтэд цэгцтэй хүргэх, хамтын ажиллагааны чиглэлээ тодорхойлох зорилгоор “Шударга өрсөлдөөн-бизнесийн амжилт” сэдэвт цуврал уузалт ярилцлагыг зохион байгуулав.

Дэлхийн банкны Монгол Улс дахь суурин төлөөлөгчийн газартай хамтран Вашингтон дахь Дэлхийн банкны төвтэй видео ярилцлага зохион байгуулж, олон улсын зөвлөх ажиллуулах, техникийн туслалцаа авах, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл солилцов.

УДИРДЛАГЫН АКАДЕМИ

“Засгийн газрын тэтгэлэгт сургалтад элсэгчдийг сонгон шалгаруулах журам”, Төрийн захиргааны удирдлага мэргэжлээр бакалаврын зэрэг олгох сургалтын элсэлтийн түр журам”, “Удирдлагын академийн элсэлтийн журам” болон “Удирдлагын академийн элсэлтийг орон нутагт зохион байгуулах журам”-ын шинэчилсэн найруулгыг батлав.

2005-2006 оны хичээлийн жилийн элсэлтийн шалгалтын бүртгэлийн ажлыг эхлээд байна.

ЗГХЭГ, Төрийн албаны зөвлөлийн захиалгат “Төрийн үйлчилгээ, түүнийг боловсронгуй болгох арга зам” сэдэвт судалгааг 10 аймгийн 20 суманд хийв.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР